



**7 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ ХИЧЭЭЛИЙН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

**ХУВИЛБАР А**

**ЭРСДЭЛ**

Буудайн хоёр үр тариан талбай дээр унажээ. Эхний үр хэлсэн нь “Би ургахыг хүсэж байна. Би өөрийн үндсээ хөрсөнд ургуулж, соёогоо газрын гадарга дээр гарган, нарны гэрлийг харж, навчин дээрээ шүүдрийн дусал буугаасай гэж хүсэж байна.” гэлээ. Удалгүй тэр хүссэнээрээ сайхан ургажээ. Харин хоёр дахь үр нь хэлсэн нь: “Би маш их айж байна. Хэрвээ би үндсээ хөрсөнд ургуулбал, харанхуйд юу болж байгааг яаж мэдэх юм. Хэрвээ би газрын гадарга дээр соёогоо дэлгээд, сайхан ишээ гэмтээчихвэл яана. Мөн сайхан дэлбээгээ дэлгэхэд, өт идчихвэл яах юм бэ?. Бүх зүйл аюулгүй болж сайн нөхцөл бүрдтэл зүгээр хэвтэж байсан дээр!” гэж хэллээ. Ингээд тэр удаан хүлээв. Хаврын нэгэн нартай өдөр нэг тахиа тариан талбай дээр гүйж яваад өнөөх ургаагүй үрийг олоод идчихжээ.

**ЭХ ДЭЭР ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР: НИЙТ ОНОО-20**

1. Эхийн сэдвийг тодорхойлоорой. /2 оноо/
  - A. Цэцэрлэгч өвгөний тухай
  - B. Хүүхдүүдийн тухай
  - C. Усан үзмийн талбайн тухай
  - D. Ажил, хөдөлмөрийн үр шимийн тухай
2. Эхийн хэсгүүдийн зөв дарааллыг олоорой. /2 оноо/
  - A. 1-р үр ургахыг хүсчээ, Хоёр үр унажээ, 1-р үр ургажээ, 2-р үр ургахаас айж, залхуурчээ, 2-р үр ургасангүй, ургаагүй үрийг тахиа иджээ.
  - B. Хоёр үр унажээ, 1-р үр ургахыг хүсчээ, 1-р үр ургажээ, 2-р үр ургахаас айж, залхуурчээ, 2-р үр ургасангүй, ургаагүй үрийг тахиа иджээ.
  - C. Хоёр үр унажээ, 1-р үр ургахыг хүсчээ, 1-р үр ургажээ, 2-р үр ургахаас айж, залхуурчээ, ургаагүй үрийг тахиа иджээ, 2-р үр ургасангүй,
  - D. Хоёр үр унажээ, 1-р үр ургахыг хүсчээ, 1-р үр ургажээ, 2-р үр ургасангүй, 2-р үр ургахаас айж, залхуурчээ, ургаагүй үрийг тахиа иджээ.
3. Бүгд тооны нэр бүхий хэсгийг олоорой. /2 оноо/
  - A. хоёр дахь, нэгдүгээр
  - B. хоёр, үр
  - C. нэгдүгээр, буудай
  - D. хоёр үр, буудай
4. Дараах өгүүлбэрээс алдаатай үгсийг олж, алдааг засаж бичээрэй. /2 оноо/

Би өөрийн үндэсээ хөрсөнд ургуулж, соёогоо газрын гадарга дээр гарган, нарны гэрэлийг харж, навчин дээрээ шүүдэрийн дусал бугаасай гэж хүсэж байна.” гэлээ.

.....  
.....

5. ХУВААЛЦАНА –Үгийг үгийн бүтцээр задалж, тайлбарлаарай. /2 оноо/

6. ҮНДЭСНИЙ БИЧИГ / 5 оноо /

Дараах галигаар бичсэн өгүүлбэрийг үндэсний бичигт хөрвүүлэн бичээрэй.

Бөгэ цэгэ нисалху

Энэ тоглагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а. Тарагачид-ун нигэ-ни тараган-а.

.....  
.....  
.....  
.....  
.....

7. УРАНЗОХИОЛ / 5 оноо /

Ц.Түмэнбаярын “Цагаан сүүний домог” тууриас...

Асуулт:

Зохиол “Тэртээ зүүн хаяанаас тэнгэр өндөрсөн үүрийн сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав аа” гэж төгсөж байгаа нь чухам ямар санааг далдуур илэрхийлж байна вэ?

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....



СУРГАЛТЫН МЕНЕЖЕР **БАТЛАВ** ГАНХЖАРГАЛ

**7 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ ХИЧЭЭЛИЙН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

**ХУВИЛБАР Б**

**ХАДАТ БУЛАГ**

Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж лайдсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ. Нэгэн удаа эрлийн хүүхэд ирж, амны цангаагаа гаргаж сууснаа дүрсгүй зан нь гэнэт хөдлөн, худгийн ёроол руу жижигхэн чулуу унагавал "шол" гэснээ сураггүй болжээ. "Том чулуу шидвэл ямар сүртэй дуугарах бол" гэж бодон хашлаганых нь бул чулууг арайхийн өнхрүүлж худагт унагавал "пол" гэсэн бөглүү дуу гарснаас өөр дорвитой ч юм болсонгүй. Тэр хүү ямар хэрэг тарьснаа ч ухаарсангүй, эрлийн замаа хөөн оджээ. Болчимгүй зантай хүүгийн бодлогогүй унагасан чулуу худгийн ёроолд унахдаа газрын гүнээс шүүрч байсан булгийн ундаргыг таг даржээ. Удсан ч үгүй худгийн ус ширгэж, хавийн ургамал гуниглан гандаж, саглагар гурван хайлаас хүртэл гиншин хатаж, мөчир нь нүцгэрэн тэнгэрээс хур гуйн сарвайв. Хайлаас дамжин жиргэж байсан богширго нисэн одож, хаа нэгтээ уянгалан байсан дуу эгшиг тасарч, эрэлчин явуулын хүмүүс ч бууж тухлахаа больж, эл хуль болон хоцорчээ. Хэнэггүй хүний хар гайгаар амьдрал хайрласан булаг хатаж, хадат биш "хадан" булаг болсон нь энэ ажээ.

**ЭХ ДЭЭР ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР: НИЙТ ОНОО-20**

1. Эхийн сэдвийг тодорхойлорой. /2 оноо/
  - A. Байгалийн тэнцвэр алдагдаж буй тухай
  - B. Хүний бодлогогүй, болчимгүй үйл ажиллагааны тухай
  - C. Хөдөө нутагт хүний суурьшил багасаж буй тухай
  - D. Ан амьтан, араатан жигүүртэн багасаж буй тухай
2. Эхийн хэсгүүдийн зөв дарааллыг олоорой. /2 оноо/
  - A. А. Хайлаас ногоорон хүглийнэ, чулуу булгийн ундаргыг таглажээ, хүүхэд худгийн ёроол руу чулуу шиджээ гурван хайлаас хатжээ, амьдрал хайрласан булаг "хадан" булаг болжээ.
  - B. В. Хүүхэд худгийн ёроол руу чулуу шиджээ, хайлаас ногоорон хүглийнэ, чулуу булгийн ундаргыг таглажээ, гурван хайлаас хатжээ, амьдрал хайрласан булаг "хадан" булаг болжээ.
  - C. Хайлаас ногоорон хүглийнэ, хүүхэд худгийн ёроол руу чулуу шиджээ, чулуу булгийн ундаргыг таглажээ, амьдрал хайрласан булаг "хадан" булаг болжээ, гурван хайлаас хатжээ,
  - D. Хайлаас ногоорон хүглийнэ, хүүхэд худгийн ёроол руу чулуу шиджээ, чулуу булгийн ундаргыг таглажээ, гурван хайлаас хатжээ, амьдрал хайрласан булаг "хадан" булаг болжээ.



3. Бүгд олон тооны утга бүхий хэсгийг олоорой. 2 оноо/

- A. хүү, чулуу
- B. чулуунууд, хайлаас
- C. чулуунууд, хүмүүс
- D. ус, хүмүүс

4. Дараах өгүүлбэрээс алдаатай үгсийг олж, алдааг засаж бичээрэй. /2 оноо/

**Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүгэлийж, түүний хөлд чулуугаар хашиж laidасан бяцхан худаг газарын нүд болон тормойж байдаг байчээ.**

5. **ЖОЛООЧИЙН** –Үгийг үгийн бүтцээр задалж, тайлбарлаарай. /2 оноо/

6. **ҮНДЭСНИЙ БИЧИГ / 5 оноо /**

Дараах галигаар бичсэн өгүүлбэрийг үндэсний бичигт хөрвүүлэн бичээрэй.

Уран шибегун-у эгүр

Борубтур өнггэ-тэи, бичихан бэи-э-тэи богшург-а-йин төрүл-үн шибегу. Модун-ду абариху-ду-бан сайин, нисхү-дэгэн хурдун тэрэ-бэр зун-у цаг-ту хорухаи шибэжи, эбүл-үн цаг-ту үр-э ургумал идэн-э.

.....  
.....  
.....  
.....  
.....

7. **УРАН ЗОХИОЛ:** /5 оноо/

П.Пүрэвсүрэнгийн “Бурханбогд аав хоёр” зохиолоос:

Зохиолд дүрслэгдэж байгаа орчинг тодруулж дэлгэрүүлж бичээрэй.

Жишээ нь: Бурханбогд энэ өглөө цагаасаа эрт босов. Гэсэн ч аав нь аль эрт ажилдаа явжээ. Бор дүрхэн тавилгатай жижигхэн байшин нь зэврүүхэн.

.....  
.....  
.....  
.....  
.....